



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 1244

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулж, байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн үйлчилгээ, дулаан сантехникийн албаны ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Ж.Ганбаатар

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Аж ахуй үйлчилгээ, дулаан  
сантехникийн албаны инженер

Гишүүд:

С.Чинзориг

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Аж ахуй үйлчилгээ, дулаан  
сантехникийн албаны барилга  
засварын хэсгийн ахлах  
мэргэжилтэн

А.Энхцэцэг

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл”  
Төрийн бус байгууллагын удирдах  
зөвлөлийн гишүүн (тохиролцсоноор)

Х.Мөнхбаяр

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл”  
Төрийн бус байгууллагын гишүүн  
(тохиролцсоноор)

Нарийн бичгийн  
дарга:

Э.Энхжин

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Хөрөнгө оруулалт, захиалагчийн  
албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ж.Ганбаатар)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжин)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/158 дугаартай “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН